



**МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2021 оны 3 сарын 11 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

**Сонгогч саналаа өгснийг илэрхийлэх
тэмдэглэгээ хийх заавар батлах тухай**


Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.5, 62.16 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Сонгогч саналаа өгснийг илэрхийлэх тэмдэглэгээ хийх заавар"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан зааврыг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны сонгуулийн хороодод, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нарийн бичгийн дарга /Д.Даваа-Очир/-д даалгасугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР

00000053

СОНГОГЧ САНАЛАА ӨГСНИЙГ ИЛЭРХИЙЛЭХ ТЭМДЭГЛЭГЭЭ ХИЙХ ЗААВАР

Нэг. Ерөнхий үндэслэл


1.1. Энэхүү зааврын зорилго нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуульд саналаа өгсөн сонгогч бүрт саналаа өгснийг илэрхийлэх тэмдэглэгээ хийх үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Санал хураалт эхлэхээс өмнө хэсгийн хорооны дарга тэмдэглэгээ хийх зориулалт бүхий бэхийг хүлээн авсан тоо ширхэг болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах ажиллагаанд хэрэглэсэн тоо ширхэгийн талаарх мэдээллийг ажиглагчдад танилцуулж, тэмдэглэл хөтөлнө.

Хоёр. Тэмдэглэгээ хийх

2.1. Санал авах байранд болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар саналаа өгсөн сонгогч бүрийн баруун гарын долоовор хурууны арьс болон хумсны толионы уг хэсгийг оруулан 0,5 см-ээс багагүй урттай байхаар эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, зориулалтын бэхээр¹ зурагт заасны дагуу зөвхөн нэг удаа тэмдэглэгээ хийж, бэх хатсан эсэхийг шалгана.

2.2. Сонгогч саналаа тэмдэглэж зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагт болон санал тоолох төхөөрөмжид саналын хуудсаа хийх буюу уншуулсны дараа энэ зааврын 2.1-т заасны дагуу тэмдэглэгээг хийнэ.



2.3. Баруун гарын долоовор хуруунд энэ журмын 2.1-д заасны дагуу тэмдэглэгээ хийх боломжгүй тохиолдолд дунд хуруунд гэх мэт боломжтой дараагийн хуруунд тэмдэглэгээ хийнэ.

2.4. Баруун гарын хуруунд тэмдэглэгээ хийх боломжгүй тохиолдолд зүүн гарын долоовор хуруунд, боломжгүй тохиолдолд дунд хуруунд гэх мэт боломжтой дараагийн хуруунд энэ журмын 2.1-д заасны дагуу тэмдэглэгээ хийнэ.

¹ БНЭУ-ын Mysore Paints and Varnish LTD компанийн “Хүний биед хоргүй” /Ink Non-Hazard Report/ гарал үүслийн гэрчилгээ бүхий бэх ISO 9001-2015, ISO 14001-2015

2.5. Гарын хуруунд тэмдэглэгээ хийх боломжгүй буюу хөгжлийн бэрхшээлийн улмаас тэмдэглэгээ хийх боломжгүй бол хэсгийн хорооны гишүүн сонгогчийн иргэний үнэмлэхийн мэдээллийг сонгогчдын нэрийн жагсаалттай тулган шалгаж, сонгогчийн овог, нэр, регистрийн дугаар болон бүртгэлийн хуудас олгосон цаг, минутыг тэмдэглэж бүртгэл хөтөлнө.

Гурав. Хариуцах ажилтан

3.1. Сонгуулийн хороод бэхийг хүлээлцэхдээ лацны бүрэн бүтэн байдлыг шалгаж, хүлээн авсан, хүлээлгэн өгсөн тоо ширхэгийг бүрэн тусгаж тэмдэглэл үйлдэнэ. Хэсгийн хорооны дарга бэх ашиглалтыг хариуцан, тэмдэглэгээ хийх гишүүнийг томилно.

3.2. Бэхийг хүргүүлэх үйл ажиллагааны хамгаалалтыг цагдаагийн байгууллага хариуцах бөгөөд тагнуулын байгууллага хяналт тавьж ажиллана.

Дөрөв. Хадгалах

4.1. Санал авах өдрийг хүртэл бэхийг саналын хуудасны хамт хадгална.

4.2. Хэрэглэгдээгүй үлдсэн бэхийг аймаг, нийслэлийн сонгуулийн хороо хэсгийн хороодоос энэ зааврын 3.1-т заасны дагуу тэмдэглэл үйлдэн хүлээн авч Сонгуулийн ерөнхий хороонд хүлээлгэн өгнө.

Тав. Хариуцлага

5.1. Энэхүү зааварт заасныг зөрчсөн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oO---